

**ӨВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭ
/2022 оны 4 дүгээр улирал/**

2022.12.22

Өвт

№	Ажлын чиглэл	Үзүүлэлт	Сум, байгууллага /тоон үзүүлэлт/	
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо	15982	
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо	430	
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл, заалтын тоо	12/38	
		Эрх мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	170
			Байгууллага	7
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	12
Байгууллага	5			
2	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж /гарсан захирамж/	А захирамж 212, Б захирамж 33 нийт 245 шийдвэр гарсан.	
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлсэн	-
			Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг	24	
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	2800	
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа	35	
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал	6000 ш	
		Радио, телевизийн нэвтрүүлэг	-	
		Сонин хэвлэлээр сурталчилсан	-	
		Бусад / цуврал video	3 удаа давхардсан тоогоор 4100 иргэн үзсэн	

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

МЭДЭЭ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ИЛТГЭХ ХУУДАС
/2022 оны 4 дүгээр улирал/**

2022 оны 12 дугаар сарын 22

Өвт

Тайлант хугацаанд эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд, Монгол Улсын хууль тогтоомж, хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Бүх нийтийн эрх зүйн боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн хуулийн шторк нэвтрүүлэг, гарын авлага зэргийг Бат-Өлзий сумын нэгдсэн бүлэг, Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудас, лэд дэлгэцээр болон олон хүнтэй пэйж хуудас, бүлгүүд рүү нийтэлж, дараах ажлуудыг зохион байгуулж ажиллаа.

Үүнд:

Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа хийх, хяналт тавих ажлын хүрээнд Төрийн албаны тухай хууль, дагалдан гарсан журмын талаарх мэдээллийг төрийн байгууллагуудын албан хаагчдад тогтмол танилцуулж, дундын грүппээр дамжуулан 260 албан хаагчдад таниулсан. Мөн гарын авлага хэлбэрээр гарган төрийн албан хаагчдад сурталчилсан. 2022 оны 11 дүгээр сарын 01-нээс 16-ны хооронд ЗДТГазар, Ахмадын хорооны даргатай хамтран “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх” төслийн хүрээнд ЗДТГазар, Цагдаагийн тасаг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд, Соёлын төвийн нийт 88 албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, харилцаа, хандлага, ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, төрийн албанд олон жил ажилласан, туршлагатай ахмадын үнэтэй зөвлөгөөг хүргэсэн.



2022 оны 10 дугаар сарын 25-нд 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хийх хяналт сэдэвт нийтийн сонголыг амжилттай зохион байгуулав. Нийтийн сонголд 50 иргэн хамрагдаж, ОНХсангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын мэдээллийг авч, журмын талаарх мэдлэгээ дээшлүүллээ.



2022.11.27-12.04-ны өдрүүдэд сумын 6 багийн иргэдийн Нийтийн хурлын IV улирлын хуралдаан болж, 577 иргэн оролцсон. Багийн иргэдийн Нийтийн хурлуудад сумын удирдлагууд болон ЗДТГ-ын мэргэжилтнүүд хууль эрх зүй, хөдөлмөр халамж үйлчилгээ, эрүүл мэнд, нийгмийн даатгал, иргэний бүртгэл, татвар, байгаль орчин, Хөдөө аж ахуй, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд мэдээлэл өгч, 2800 ш гарын авлага тараан, зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан.

Энэ удаагийн багийн хурлуудад Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдорж оролцож, цаг үеийн байдлаар мэдээлэл өгч иргэдийн санал, хүсэлтийг сонслоо.



2022 оны 11 дүгээр сарын 18-нд Бат-Өлзий сумын ЕБС, ГХУСАЗСЗөвлөл хамтран “ТОМЧУУДАД ХЭЛЭХ БИДНИЙ ҮГ” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэг нь үүсч болох аюулаас урьдчилан сэргийлэх, утас дэлгэц, электрон тамхи зэргийн хор хөнөөлийг сурталчлан таниулах, хүүхдийг хохирогч болгох, мөлжих, тэднийг гэмт хэрэгт ашиглах үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээлэл өгөх, уншсан номын утга агуулгаар дамжуулан тэдний ёс зүй хүмүүжил төлөвшилд нөлөөлөх зорилготой үйл ажиллагаа юм.




Хүүхдийг хохирогч болгох, мөлжих, тэднийг гэмт хэрэгт ашиглах үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх гарын авлага хийж 100 хүүхэд, 50 эцэг, эхэд тараасан.



Бүх нийтийн эрх зүйн боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын нэг цэгийн үйлчилгээний төвд “Эрх зүйн хөтчийн булан нээж, иргэдэд E-KHUTUCH.MN хууль зүйн зөвлөгөө мэдээллийн цахим сангаас үйлчилгээ үзүүлж, шаардлагатай иргэдэд өргөдөл, хүсэлтийг бичиж өгч, E-Mongolia.mn-ээс иргэдэд лавлагаа мэдээллийг гарган, хуулийн анхан шатны зөвлөгөөг өгч байна. Засаг даргын Тамгын газар нь 2022 оны 09 дүгээр сараас эхлэн эрх зүйн хөтчийг гэрээгээр ажил гүйцэтгүүлэн ажиллаж байна. Эрх зүйн хөтчийн булангаар дамжуулан 400 гаруй иргэн үйлчилгээ авсан байна.




Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн мэргэжилтэн Г.Доржханд Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудсаар хууль сурталчилсан богино хэмжээний цуврал бичлэг хийж иргэдэд хуулийн сурталчилгааг ойлгомжтой хэлбэрээр түгээсэн. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дах хэсэг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар”, “Архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагын талаар, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24,6 дахь хэсэгт Хууль бус мод бэлтгэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хуулийг иргэдэд сурталчилсан. Бичлэгийг 1900 гаруй иргэн үзэж сэтгэгдэл өндөр байсан.



2022 оны мал тооллогын үеэр ЗДТГ-ын мэргэжилтнүүд салбар чиглэлээрээ хуулийн гарын авлага бэлтгэн ажлын хэсгийн гишүүдээр дамжуулан иргэдэд 900 ширхэг гарын авлага материал тарааж иргэдэд хууль, эрх зүйн мэдээллийг хүргэсэн.

/Сэдэв: Хууль бус мод бэлтгэлээс сэргийлье”, “Зэрлэг ан амьтан таны гарт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлье, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хуулийн заалт, Малын тоо толгойн албан татварын тухай, Нэн ховор, ховор амьтан, ургамлын тухай, сарлагийн ширийг стандартын дагуу зөв боловсруулах арга гэх мэт/





Засаг даргын Тамгын газар, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран 2022 оны 10-р сард “Амьдрах ухааны сургалт”-ыг зохион байгуулсан. Сургалтад 80 иргэн хамрагдаж өрхийн үйлдвэрлэл эрхлэх, бизнесээ хөгжүүлэх, санхүүгийн тооцоолол хийх зэрэг мэдлэгт суралцсан.

Цэрэг татлагын үеэр ЗДТГазар, Эрүүл мэндийн төвтэй хамтран 312 цэргийн насны залууд ДОХ, тэмбүүгүн талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулсан. ЕБС-ийн Залуу эмч клуб, өсвөрийн аврагч клуб үйл ажиллагааны чиглэлээ гаргаж, 2022 оны 12-р сарын 01-ний өдөр ДОХ/БЗДХ сэдвээр мэтгэлцээн зохион байгуулж, нийт 46 сурагч хамрагдсан.

2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Бат-Өлзий сумын ГХУСАЗСЗөвлөл, ЕБС-тай хамтран “Охидын ертөнц” уулзалт хэлэлцүүлгийг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж 140 сурагч охид хамрагдлаа. Хэлэлцүүлэгт:

- ✓ Эмэгтэйчүүдийн манлайлал / ЕБС-ийн захирал Б.Ууганчимэг/
- ✓ Үнэ цэнэтэй амьдрах нь /сумын Соёлын төвийн ОНСТ-ийн ажилтан Г.Хорол-Эрдэнэ /
- ✓ Дэлхийн улс орнуудын охид эмэгтэйчүүдийн талаарх асуудал /МХУран зохиолын багш Ц.Мөнхцэцэг/
- ✓ Үгийн хүч /МХУЗ-ын багш Б.Даваажав/
- ✓ Эмчийн зөвлөгөө /ЭМТ-ийн нийгмийн ажилтан Г.Ганчимэд/ нар өөрсдийн амьдралын туршлага санал бодлоо солилцож, охидод үнэтэй зөвлөгөө өгөн нэгийг бодуулж, хоёрыг тунгаасан үйл ажиллагаа боллоо.



Бат-Өлзий сумын 1, 6 дугаар багийн иргэдэд сүү, цагаан идээ боловсруулах сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 186 малчин эмэгтэй оролцож, сүү, цагаан идээгээ эрүүл ахуйн шаардлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанартай, олон төрлийн бүтээгдэхүүн боловсруулах мэдлэг, чадварт суралцсан.



Бат-Өлзий сумын ЕБСургуулиас сурагчийг сургуульд ирэх, буцах замын ойр орчны аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсэд үнэлгээ хийж, эрсдэлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ангийн эцэг, эхийн хурлаар дамжуулан гэрээс сургууль хүртэлх “Аюулгүй зураглал” хэрхэн хийх талаарх сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 25-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад 3 бүлгийн 73 эцэг, эх, асран хамгаалагч хамрагдсан.



ЕБСургуулиас 2022 оны 11, 12-р саруудад зохион байгуулсан “Gen z ба хөдөлмөрийн зах зээл” сэдэвт сургалт, “Хүүхдийн хөгжилд миний оролцоо” сэдэвт сургалт, “Хүүхдийн эрх ба хүүхдийн эсрэг хүчирхийлэл” сэдэвт сургалт, “Дэлгэцэд донтох эмгэг” сэдэвт сургалтуудад нийт 80 эцэг, эх, асран хамгаалагч тус тус хамрагдсан.





2022 оны 11 дүгээр сард “Харилцаа хандлага-хүүхдийн хүмүүжилд”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхэд эцэг, эхийн оролцоо”, “Угийн бичиг хөтлөхийн ач тус” сургалтад ЕБС-ийн сурагчдын 88 эцэг, эх хамрагдсан. 179 сурагч “Хүүхэд хамгаалал, эерэг хандлага ба хорт зуршил” сургалтад, мэргэжлийн сэтгэл зүйчээс 44 сурагч ганцаарчилсан зөвлөгөө, 6 ангийн 186 сурагч бүлгийн зөвлөгөө авсан. Зөвлөгөө авсан сурагчдын дийлэнх нь архины давхар хамаарлын чиглэлээр зөвлөгөө авсан. Энэхүү үйл ажиллагааг Сумын ЗДТГазар, аймгийн ГБХЗХГазартай, Мөн ЕБСургууль мэргэжлийн сэтгэл зүйчийг урьж хамтран зохион байгуулсан.



Мөн Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн “Хүүхэд хамгаалалд эцэг, эхийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад 1-12-р ангийн 45 эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл оролцсон.



2022 оны 09 дүгээр сарын 09-нд Бат-Өлзий сумын 1-р цэцэрлэгийн эрхлэгч Н.Батжаргал, арга зүйч Р.Гэрэлт-Од нар 1, 2 дугаар цэцэрлэгийн багш ажилчдад “Гэр бүл хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад төрийн албан хаагчдын үүрэг оролцоо, хариуцлага” сэдэвт сургалт зохион байгууллаа.



Тайлант хугацаанд 1-р цэцэрлэгийн эмч Т.Цэнгэлдулам “Осол гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?”, “Нурууны суултаас хэрхэн сэргийлэх вэ?”, “Гар утсыг буруу хэрэглэснээр хүүхдэд ямар хор хөнөөлтэй болох вэ” сэдэвт сургалтуудад давхардсан тоогоор 448 эцэг, эх хамрагдсан. Эцэг, эхийн нэгдсэн групп чатаар “Улирлын чанартай томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх”, “Гар утсыг буруу хэрэглэснээр хүүхдэд ямар хор хөнөөлтэй болох вэ” сэтгэцэд яаж нөлөөлөх талаар зөвлөмж бэлтгэн мэдээллэхэд нийт 204 эцэг эх хамрагдлаа.

2022 оны 11 дүгээр сарын 29-нд 1 дүгээр цэцэрлэгийн эмч, тогооч нар “Эрүүл зөв хооллолт” амталгаа, сургалт зохион байгуулж, зөвлөмж бэлтгэн 10 бүлгийн 75 эцэг, эх тараасан.



2 дугаар цэцэрлэгээс хүүхдүүдийн эцэг, эхчүүдэд “4 настай хүүхдийн онцлог болон хэрхэн харилцах талаарх сургалт”, “Хүүхдийн эрүүл мэндийн дадал хэвшил олгох сургалт”, “Орчны аюулгүй байдал, хүүхдийн хоол тэжээлийн хэрэгцээ сургалт”-ыг тус тус зохион байгуулж, нийт 88 эцэг, эх хамрагдсан.



2022 оны 4 дүгээр улиралд эрх, зүйн сургалт, хэлэлцүүлэг 24 удаа явуулж, 2800-аад иргэн хамрагдаж, 35 сэдвээр эрх зүйн сурталчилгааны 6000 гаруй гарын авлага, сурталчилгааны материал боловсруулан тарааж ажилласан байна.

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД